



## “МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 24/23

Улаанбаатар хот

### Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам батлах тухай


Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодексын 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3.16 дахь заалт, 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын дагуу сонирхлын зөрчил үүссэн эсэх тайлбар, нэгдмэл сонирхолтой болон, хамаарал бүхий этгээдийн судалгааг гарган төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлэхийг “Монгол шуудан” ХК-ийн эрх бүхий албан тушаалтнуудад даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хорооны дарга (Д. Балдорж)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



## **“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх үүднээс сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн дүрэм болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.3. Журамд дурдсан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 1.3.1. “Нийтийн албан тушаалтан гэж” Төрийн өмчийн оролцоотой “Монгол шуудан” ХК-ийн удирдах болон эрх бүхий албан тушаалтныг,
  - 1.3.2. “Эрх бүхий албан тушаалтан гэж” Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан этгээдүүдийг,
  - 1.3.3. “Нийтийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг;
  - 1.3.4. “Хувийн ашиг сонирхол” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
  - 1.3.5. “Ашиг сонирхлын зөрчил” гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;
  - 1.3.6. “Хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;
  - 1.3.7. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;
  - 1.3.8. “Сонирхлын зөрчил бүхий этгээд гэж” Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан компанитай хэлцэл хийх этгээдийг,
  - 1.3.9. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж” Сонирхлын зөрчил бүхий этгээдийн компанитай байгуулах хэлцлийг,
  - 1.3.10. “Их хэмжээний хэлцэл гэж” Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан хэлцлийг

### **ХОЁР. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ**

- 2.1. Дараах их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг Хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэнэ. Үүнд:
  - 2.1.1. Хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;
  - 2.1.2. Компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу

түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;

- 2.1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх,
  - 2.1.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх шийдвэр гаргасан хэлцэл,
  - 2.1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхын саналаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргасан хэлцэл,
- 2.2. Энэ журмын 2.1 дэх хэсэгт зааснаас бусад хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
  - 2.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргана.

### **ГУРАВ. МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР ГАРГАХ, НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД, ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ**

- 3.1. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, мэдэгдэл, тайлбар бүртгэх эрх бүхий албан тушаалтан, шууд удирдлагад хүргүүлнэ.
- 3.2. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн тохиолдолд тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.
- 3.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.1 дэх хэсэгт заасны дагуу албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдийн жагсаалтыг гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 хоногийн дотор компанид мэдэгдэнэ.
- 3.4. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй

### **ДӨРӨВ. БУСАД**

- 4.1. Энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулна.
- 4.2. Журмын биелэлт, хэрэгжилтэд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитор хяналт тавьж ажиллана.